ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:СНАГ-2025/64/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас:261740 Цахим хаяг:Lkhagvasurenm@audit.gov.mn
Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал: П.Насанбуян
Утас:99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа 10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт 11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл 12
4. АУДИТЫН ТАЙЛАН 14
4.1 Ерөнхий зүйл 14
4.2 Материаллаг байдал 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 17
5.1 Төлбөрийн акт 17
5.2 Албан шаардлага 17
5.3 Зөвлөмж 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд багууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1069

танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Э.ГАНХҮҮ ТАНАА

Өөрчлөлттүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт , түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх тухай гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/35 дугаар тушаалын дагуу 2 ажилтанд урт хугацаанд тогтвортой ажиллах гэрээ байгуулж тус бүр 200.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрдэнэс оюу толгой ХХК нь тайлант онд Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу 2023 оны цэвэр ашгаас 342.8 сая төгрөгийг Эрдэнэс монгол ХХК-ийн дансанд төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант хугацаанд Эрдэнэс монгол ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор тус компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн гүйцэтгэх захирал, 1 газар, 7 хэлтэстэй 31 хүний орон тоотой байхаар батлагдсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */төгрөгөөр/*

Д/Д	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	**Эргэлтийн хөрөнгө**		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	10,646,717,728.76	5,970,783,349.78
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	4,779,504.38	5,221,293.38
1.1.4	Бусад авлага	3,922,161.11	-
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	5,774,105,895.00
1.1.20	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**10,655,419,394.25**	**11,750,110,538.16**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**		
1.2.1	Үндсэн хөрөнгө	258,515,949.94	583,318,025.03
1.2.2	Биет бус хөрөнгө	34,623,075.15	30,477,160.29
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.20	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**2,748,075,559,025.09**	**2,748,396,215,185.31**
1.3	**НИЙТ ХӨРӨНГӨ**	**2,758,730,978,419.34**	**2,760,146,325,723.47**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**		
2.1	**ӨР ТӨЛБӨР**		
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	3,652,566,673.62	563,760,204.62
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	5,070,778,341.47	5,648,543,124.54
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	43,172,040.00	38,575,506.68
2.1.1.20	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**8,766,517,055.09**	**6,250,878,835.84**
2.1.2	**Урт хугацаат өр төлбөр**		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	6,237,342,391.16	6,373,679,430.00
2.1.2.20	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**6,237,342,391.16**	**6,373,679,430.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**15,003,859,446.25**	**12,624,558,265.84**
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Төрийн өмч	300,000,000.00	300,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,355,301,026.91)	(560,652,542.37)
2.3.20	**Эздийн өмчийн дүн**	**2,743,727,118,973.09**	**2,747,521,767,457.63**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**	**2,758,730,978,419.34**	**2,760,146,325,723.47**

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон */төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	17,513,121,763.64	9,949,406,836.36
3	Борлуулалтын өртөг	-	-
4	**Нийт ашиг (алдагдал)**	**17,513,121,763.64**	**9,949,406,836.36**
6	Хүүгийн орлого	78,244,518.10	139,163,982.84
11	Ерөнхий ба удирдлагын зардал	15,681,783,582.71	4,585,263,990.07
12	Санхүүгийн зардал	799,791,684.93	714,101,821.92
13	Бусад зардал	5,242,856.00	279,500,290.00
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	16,508,637.15	(14,054,566.38)
19	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**1,121,056,795.25**	**4,495,650,150.83**
20	Орлогын татварын зардал	112,629,965.12	477,515,044.08
21	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**1,008,426,830.13**	**4,018,135,106.74**
23	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**1,008,426,830.13**	**4,018,135,106.74**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон */төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**300,000,000.0**	**2,747,782,420,000.00**	**(5,363,727,857.04)**	**2,742,718,692,142.96**
3	**Залруулсан үлдэгдэл**	**300,000,000.0**	**2,747,782,420,000.00**	**(5,363,727,857.04)**	**2,742,718,692,142.96**
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,008,426,830.13	**1,008,426,830.13**
9	**2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**300,000,000.0**	**2,747,782,420,000.00**	**(4,355,301,026.91)**	**2,743,727,118,973.09**
11	**Залруулсан үлдэгдэл**	**300,000,000.0**	**2,747,782,420,000.00**	**(4,355,301,026.91)**	**2,743,846,497,473.09**
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			4,018,135,106.74	**4,018,135,106.74**
13	Бусад дэлгэрэнгүй орлого			119,378,500.00	119,378,500.00
15	Зарласан ногдол ашиг			(342,865,122.20)	**(342,865,122.20)**
	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	**300,000,000.0**	**2,747,782,420,000.00**	**(560,652,542.37)**	**2,747,521,767,457.63**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	**19,264,433,940.00**	**11,063,726,020.00**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	19,264,433,940.00	10,944,347,520.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		119,378,500.00
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	**8,551,693,124.83**	**6,798,222,294.53**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,137,463,374.90	1,517,561,441.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгуулллагад төлсөн	480,900,000.00	504,317,366.54
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	41,829,869.82	39,712,250.45
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	134,000.00	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,247,344,561.69	4,670,817,544.82
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,644,021,318.42	65,813,691.72
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**10,712,740,815.17**	**4,265,503,725.47**
2.00	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	**118,429,985.29**	**158,734,107.20**
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	40,185,467.19	19,570,124.36
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	78,244,518.10	139,163,982.84
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**532,127,310.72**	**659,086,950.00**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	42,918,256.48	12,269,600.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,900,000.00	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	485,309,054.24	646,817,350.00
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(413,697,325.43)**	**(500,352,842.80)**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	**1,888,320.30**	**13,222,810.91**
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,888,320.30	13,222,810.91
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**8,693,699,613.59**	**8,440,253,506.18**
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	8,693,699,613.59	8,097,388,383.98
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	342,865,122.20
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(8,691,811,293.29)**	**(8,427,030,695.27)**
4	Валютын ханшийн зөрүү	**(25,772,075.46)**	**(14,054,566.38)**
5	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**1,581,460,120.99**	**(4,675,934,378.98)**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**9,065,257,607.77**	**10,646,717,728.76**
7	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**10,646,717,728.76**	**5,970,783,349.78**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */мянган төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	**Нийт үйл ажиллагааны орлогын дүн**	**17,513,121.8**	**17,711,719.9**	**10,088,569.8**	**(7,623,150.1)**	**57.0**
1.1	Ажил үйлчилгээний орлого	17,513,121.8	17,711,719.9	9,949,405.8	(7,762,314.0)	56.2
1.2	Хүүгийн орлого		-	139,163.9	139,163.9	
	Цалин нийгмийн хамгаалллын зардал	**2,161,654.4**	**2,244,510.5**	**2,118,699.8**	**(125,810.7)**	**94.4**
2.1	Цалингийн зардал	1,830,839.2	1,995,120.5	1,884,174.3	(110,946.2)	94.4
2.2	Нэмэгдэл цалин	91,775.4				
2.3	НДШ зардал	239,039.8	249,390.0	234,525.5	(14,864.5)	94.0
	Урсгал зардлын тесөв	**14,319,920.8**	**15,324,912.9**	**3,474,219.8**	**(11,850,693.1)**	**22.7**
2.4	Бичиг хэргийн зардал	9,707.5	18,445.3	6,110.8	(12,334.5)	33.1
2.5	Вэб сайт интернэтийн зардал	34,398.0	52,274.7	32,790.3	(19,484.4)	62.7
2.6	Шуудан холбооны зардал	8,803.3	5,540.0	3,555.3	(1,984.7)	64.2
2.7	Машин үйлчилгээ сэлбэг	6,989.0	19,700.0	4,500.0	(15,200.0)	22.8
2.8	Гэрээт ажлын зардал	226,000.0	335,000.0	184,600.0	(150,400.0)	55.1
2.9	Санхүүгийн тайлан баталгаажуулах зардал	9,900.0	20,000.0	9,900.0	(10,100.0)	49.5
2.10	Гадаад, дотоод сургалт, зар сурталчилгааны	6,440,759.1	4,447,032.5	3,644.6	(4,443,387.9)	0.1
2.11	Шатахууны зардал	14,048.4	11,639.5	11,184.2	(455.3)	96.1
2.12	Байрны урсгал зардал		235,964.9	163,166.8	(72,798.1)	69.1
2.13	Зочид төлөөлөгчийн зардал	698,940.0	165,693.8	10,885.0	(154,808.8)	6.6
2.14	Ном, хэвлэл захиалгын зардал	4,250.0	12,350.9	1,510.2	(10,840.7)	12.2
2.15	Гадаад томилолтын зардал	712,060.0				
2.16	Дотоод томилолтын зардал		459,661.1	180,355.8	(279,305.3)	39.2
2.17	Түрээсийн зардал	472,164.8	235,000.0	353,151.6	118,151.6	150.
2.18	Ажилтнуудын нийгмийн асуудал, арга хэмжээ	5,242.9	43,260.0	2,519.0	(40,741.0)	5.8
2.19	Хангамжын материалын зардал	18,028.0	23,992.0	5,801.8	(18,190.2)	24.2
2.20	Даатгал ба эрсдэлийн зардал	226.3	15,225.0	391.3	(14,833.7)	2.6
2.21	Зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал	4,024,222.9	6,356,588.8	1,011,430.2	(5,345,158.6)	15.9
2.22	Боловсон хүчний аж	600,000.0	600,000.0	500,000.0	(100,000.0)	83.3

	ахуйн хангамж					
2.23	Ханбогд теслийн зардал	130,000.0	430,000.0	12,300.0	(417,700.0)	2.9
2.24	Хэрлэн Тооно теслийн зардал		372,553.6	152,350.0	(220,203.6)	40.9
2.25	Зээлийн хүүгийн зардал	600,000.0	800,000.0	714,101.8	(85,898.2)	89.3
2.26	Элэгдлийн зардал	104,180.7	310,756.3	95,916.4	(214,839.9)	30.9
2.27	Менежментийн төлбөр		354,234.4	-	(354,234.4)	-
2.28	Гадаад валютын ханшийн зөрүү		-	14,054.6	14,054.6	
2	**Нийт зардлын дүн**	**16,481,575.3**	**17,569,423.5**	**5,592,919.6**	**(11,976,503.8)**	**31.8**
3	Татварын өмнөх ашиг		142,296.4	4,495,650.1	4,353,353.7	-
3.1	Орлогын татварын зардал		14,229.6	477,515.0	463,285.4	-
4	**Хөрөнгө оруулалт**	**46,818.3**	**9,496,150.5**	**6,158,650.0**	**(3,337,500.5)**	**64.9**
3.1	Компьютер, дагалдах хэрэгсэл	18,803.5	61,202.1	-	(61,202.1)	-
3.2	Тавилга, эд хогшил	19,108.4	164,948.4	116,850.0	(48,098.4)	70.8
3.4	Тээврийн хэрэгсэл		270,000.0	268,900.0	(1,100.0)	99.6
3.5	Архивын програм,т/т	3,545.5				
3.6	Барилга, байгууламж		8,500,000.0	5,772,900.0	(2,727,100.0)	67.9
3.7	Уул уурхайн программ		500,000.0	-	(500,000.0)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн эрхэм зорилго нь "Монгол Улс, ард иргэдийнхээ эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, төслийн өгөөжийг дээшлүүлэн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, удирдах эрхийг хэрэгжүүлэх" бөгөөд Стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой ордод үйл ажиллагаа явуулж буй Оюу Толгой ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх" гэсэн үндсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчийн хувьд "Оюу Толгой" ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох;
- Оюу Толгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх;
- Төрд ногдох ашгийг төвлөрүүлэх.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай, емчийн 100 хувийг компанийн үүсгэн байгуулагч бөгөөд төрийн мэдлийн хувьцааг эзэмшигч Эрдэнэс Монгол ХХК байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрдэнэс оюу толгой ХХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 348 дугаар тогтоол, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн емчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн емчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын емне хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн емчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах" гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тус компанийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалттай нийцэж байна.

Эрдэнэс оюу толгой ХХК нь Ашигт малтмал түүнтэй холбоотой бусад хуулиуд, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Гадаадын хөренгө оруулалтын тухай, Газрын хэвлийн тухай, Тесвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд Эрдэнэс оюу толгой ХХК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Үндэсний баялгийн сангийн тухай хууль

- Ашигт малтмалын тухай хууль /нэмэлт өөрчлөлт/
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ний өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 139 дүгээр тогтоол.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрдэнэс Монгол нэгдлийн охин, харьяа компаниудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналтаар тус компанид ажил сайжруулах,хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан бичиг ирсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байсан бөгөөд компанийн үйл ажиллагааны онцлогт нийцэхгүй байсан тул шинэчлэн боловсруулж, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 76 дугаар тогтоолоор батлуулж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэгдлийн хэмжээнд мөрдүүлэхээр болсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,415.3 сая төгрөгөөр буюу 0.05 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Менген хөрөнгө	10,646,717.7	5,970,783.3	(4,675,934.4)
Авлага	4,779.5	5,221.3	441.8
Бараа материал	3,922.2		(3,922.2)
Урьдчилж төлсөн тооцоо		5,774,105.9	5,774,105.9
Үндсэн хөрөнгө	258,515.9	583,318.0	324,802.1
Биет бус хөрөнгө	34,623.1	30,477.1	(4,146.0)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782,420.0	2,747,782,420.0	00
Нийт хөрөнгө	**2,758,730,978.4**	**2,760,146,325.7**	**1,415,347.3**
Богино хугацаат өр төлбөр	8,766,517.0	6,250,878.8	(2,515,638.2)
Урт хугацаат өр төлбөр	6,237,342.4	6,373,679.4	136,337.0
Эздийн өмч	2,743,727,118.9	2,747,521,767.4	3,794,648.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**2,758,730,978.4**	**2,760,146,325.7**	**1,415,347.3**

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Менген хөрөнгө дансны үлдэгдэл 4,675.9 сая төгрөг буюу 43.9 хувиар буурсан нь тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу оффисын барилга худалдан авахад 5,772.9 сая төгрөг төлсөн нь нөлөөлсөн байна.

Авлагын дансны үлдэгдэл 5.2 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл 5,774.1 сая төгрөг нь дээрхи оффисын 70 хувийн урьдчилгаа төлбөр болон түүний тохижилттой холбоотой хөшигний урьдчилж төлсөн төлбөрөөс үүссэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 324.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 276.6 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл,140.0 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч, 91.8 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 2,515.6 сая төгрөгөөр буурсан нь улсын төсөвт төлөх татварын өр 3,088.8 сая төгрөгөөр буурч, зээлийн хүүгийн өглөг 577.7 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Тус компанийн үйл ажиллагааны зардлыг санхүужүүлэх зорилгоор толгой компани буюу "Эрдэнэс Монгол" ХХК-тай зээлийн гэрээ байгуулж, 2012-2021 онуудад үүссэн зээлийн хүүгийн хуримтлагдсан өр 5,648.5 сая төгрөг, үндсэн зээлийн өр 6,373.6 сая төгрөгийн өр төлбөрийг оны эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 3,794.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны цэвэр ашиг 4,018.1 сая төгрөг, өмнөх оны зардал бууруулсан 119.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндэсний баялагийн санд 342.8 сая төгрөгийн ногдол ашиг төлөрүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө/ боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны 99 дугаар тогтоолоор Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2024 оны төсөв, хөрөнгө

оруулалтын төлөвлөгөөг баталж нийт орлогыг 18,666.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 17,715.5 сая төгрөгөөр цэвэр ашгийг 856.0 сая төгрөг байхаар төлөвлөж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 13,462.7 сая төгрөг зарцуулахаар баталсаныг 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна. Үүнд тайлант оны нийт орлогыг 17,711.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 17,569.4 сая төгрөгөөр баталж, 128.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 9,496.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Тайлант онд гүйцэтгэлээр 9,949.4 сая төгрөгийн ажил үйлчилгээний орлого,139.1 сая төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж, 5,592.9 сая төгрөгийн зардал гарган, 4,495.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 9,949.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 7,762.3 сая төгрөг буюу 43.8 хувиар тасарсан нь "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 274 дүгээр тогтоолын 51 дэх хэсэгт заасны дагуу Оюу толгой төсөлд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх, төслийн менежментийг сайжруулах зорилгоор гэрээний үндсэн дээр олгох санхүүжилт 7,381.0 сая төгрөгөөр дутуу, Хэрлэн тооно төслийн судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажил хийгдээгүйгээс 381.3 сая төгрөгийн орлого орж ирээгүйтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 5,578.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11,990.5 сая төгрөг буюу 68.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь "Оюу Толгой" төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор Лондон хотын арбитрын шүүхэд материал өгөх судалгаа, мэргэшсэн шинжээч, аудиторууд авч ажиллуулахаар 10,741.8 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд эдгээр ажлууд хийгдээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна. Мөн "Ханбогд төсөл", "Хэрлэн тооно" төслийг хэрэгжүүлэхэд 802.5 сая төгрөг төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 164.6 төгрөгийн зардал гаргасан байна.

Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардалд арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9,496.1 сая төгрөгийн барилга, тэзэрийн хэрэгсэл, тавилга эд хогшил, уул уурхайн программ хангамж худалдаж авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6,158.6 сая төгрөг буюу 64.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр ашгийг 128.0 сая төгрөг байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,018.1 сая төгрөг байгаа нь тайлант онд дээрх ажлууд хийгдээгүйтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Эрдэнэс оюу толгой ХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тус компанийн дотоод хяналтыг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, нягтлан бодох бүртгэлийн хуулийг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ажу мэргэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Насанбуян, аудитор Д.Наранчимэг, гэрээт аудитор Л.Хонгорзул, туслах аудитор Д.Шандбаяр нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Долгорсүрэн анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор М.Лхагвасүрэн, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс оюу толгой ХХК 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлого 17,607.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 176.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тайлант онд үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна.

Тайлант онд түрээсийн зардлыг батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөөнөөс 118.2 сая төгрөг буюу 50.3 хувиар хэтрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32 мөнгөн гүйлгээ байршуулаагүй, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлийг ил тод байршуулаагүй, төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх гэрээ нь 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан тул завсрын аудитад хамрагдаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн 49.7 сая төгрөгийн зөрчлөөс 3.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 45.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 1 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт 80.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,766.0	2	3,766.0	100.0
Зөвлөмж	2	45,890.0	2	45890.0	100.0
Нийт дүн	**5**	**49,656.0**	**4**	**49,656.0**	**80.0**

Өмнөх онд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлснийг тайлант онд давтан гаргасан тул сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нэр бүхий компанитай байгуулсан "Барилга байгууламж худалдаж авах тухай" гэрээний хэрэгжилтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14.2 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс 2.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2.1 төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага, 10.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 14.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 176.1 сая төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Албан томилолтоор орон нутагт ажилласан ажилтнуудад 2.1 сая төгрөгийн байрны зардлыг илүү олгосон, мөн томилолтын үнэмлэх бичиж тооцоог хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалын заалттай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Илүү олгосон байрны зардлын үнийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Нэр бүхий компанитай 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр 8,247.0 сая төгрөгийн "Барилга байгууламж худалдаж авах тухай" гэрээ байгуулсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр дээрх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, үнийн дүнгийн 70 хувь буюу 5,772.9 сая төгрөгийн урьдчилгааг гүйцэтгэгч компанийн дансанд шилжүүлсэн боловч одоог хүртэл барилгыг хүлээн аваагүй, гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулаагүйгээс оффисын түрээсийн үргүй зардал гаргаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно", 40.2.1 "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Үр ашигтай байх", "Барилга байгууламж худалдаж авах тухай" гэрээний тусгай нөхцөлд төлбөр төлөх хугацааг "Нийлүүлэгч барилга байгууламжийг захиалагчид хүлээлгэн өгч, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний өмчлөх эрхийг шилжүүлсний дараа 14 хоногийн дотор төлбөрийг бүрэн шилжүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Барилга байгууламж худалдаж авах тухай гэрээний дагуу гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулаагүйгээс оффисын түрээсэнд олон сараар үргүй зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх оны аудитаар тогтоосон актын төлбөр 2.1 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны

байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон актын төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр авлага үүсгэж, барагдуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Түрээсийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус компани нь Дархан төмөрлөгийн үйлдвэр, ТӨБЗГ-тай гурвалсан гэрээ байгуулж 2024 оны 5 дугаар сард "Блью Скай" тауэрын 8 давхарт 374.65 метр квадрат оффисын талбайг түрээслэхдээ нэг м.кв-ийн 1 сарын түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан бусдаас байр түрээслэх дээд хязгаараас 0.04 сая төгрөгөөр илүү үнээр гэрээ байгуулж нийт 170.8 сая төгрөгийн илүү зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", ТӨБЗГ-ын 2024 оны "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай" 139 дүгээр тогтоолын 1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1 м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50,000 төгрөгөөр тогтоосугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай" 139 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд орон нутагт томилолтоор ажилласан ажилтнуудтай албан томилолтын үнэмлэх бичиж тооцоо хийдэггүй, шатахууны тооцоог замын хуудас, явсан км, автомашины шатахуун зарцуулалтын нормыг баримталж олгоогүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу 10.0 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2 "... төлбөр тооцооны толлого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажиллах ажилтнуудад албан томилолтын үнэмлэх олгож, түүнийг үндэслэн дараа тайлангийн тооцоог хаах, жолоочийн тооцооны хуудсыг үндэслэн шатахууны тооцоог бодож байх.

3. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор толгой компани буюу Эрдэнэс Монгол ХХК-иас 2012-2021 оны хугацаанд авсан үндсэн зээл, хуримтлагдсан зээлийн хүүгийн төлбөр 12,022.2 сая төгрөгийн өртэй байгаа нь тус компанийн төлбөрийн чадварыг илэрхийлэх санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцаа алдагдсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 "Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ", 47.1 "Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна: 47.1.1 ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх", 47.1.2 "ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 30.5-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх", Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 14.3 "Энэ хуулийн 14.2-т заасныг үл харгалзан хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг гурав дахин нэмэгдүүлснээс илүү хэмжээний тухайн хөрөнгө оруулагчийн зээлд төлсөн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Толгой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд санхүүгийн зохистой харьцаа алдагдсан асуудлыг танилцуулж, компанийн ашигт ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар тогтоосон актын төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	1	2,140.4	-	-	1	2,140.4	-	-	-	-	-	-
Албан томилолтоор орон нутагт ажилласан ажиллагсдад 2.1 сая төгрөгийн байрны зардлыг илүү олгосон, мөн томилолтын үнэмлэх бичиж тооцоо хийгээгүй байна.	1	2,085.0	1	2,085.0	-	-	-	-	-	-	-	-
Нэр бүхий компанитай 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр 8,247.0 сая төгрөгөөр "Барилга байгууламж худалдаж авах тухай" гэрээ байгуулсан, 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр дээрх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, үнийн дүнгийн 70 хувь буюу 5,772.9 сая төгрөгийн урьдчилгааг гүйцэтгэгч компанийн данснд шилжүүлсэн боловч одоог хүртэл барилгыг хүлээн авч гэрээний үүргийг хангуулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
2024 оны 5 дугаар сард "Блью Скай" тауэрын 8 давхарт 374.65 м2 оффисын талбайг түрээслэх түрээсийн гэрээ байгуулахдаа 1м.кв-ийн 1 сарын түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан дүнгээс 38,000 төгрөгөөр илүү байхаар тохиролцож нийт 170.8 сая төгрөгийн илүү зардал гаргасан.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Орон нутагт албан томилолтоор ажилласан ажилтнуудтай албан томилолтын үнэмлэх бичиж тооцоо хийдэггүй, шатахууны тооцоог замын хуудас, явсан км, автомашины шатахуун зарцуулалтын нормыг баримталж олгоогүй зэрэг	1	10,003.3	-	-	-	-	1	10,003.3	-	-	-	-

анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.												
Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор толгой компани буюу Эрдэнэс Монгол ХХК-иас 2012-2021 оны хугацаанд авсан үндсэн зээл, хуримтлагдсан зээлийн хүүгийн төлбөрт 12,022.2 сая төгрөгийн өртэй байгаа нь тус компанийн төлбөрийн чадварыг илэрхийлэх санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцаа алдагдсан байна	1		-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	6	14,228.7	1	2,085.0	2	2,140.4	3	10,003.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32 мөнгөн гүйлгээ байршуулаагүй, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.	1	-	1	-	-	-
Дүн	1	-	1	-	-	-

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14 № 158/A0150458 Улаанбаатар хот
СНМТ-2025/064/НА-СТА-ТОИГ

Телбер барагдуулах тухай

Терийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Терийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зерчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор орон нутагт ажилласан ажиллагсдад 2,085,000.00 /хоёр сая наян таван мянган/ тегрегийн байрны зардлыг илүү олгосон, мен томилолтын үнэлэх олгож тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хетлех, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зев гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Тесвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, тесвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "тесвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар телевлеж, зарцуулах" Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалын заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Терийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд тесев, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон тесвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн емч, херенге олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зерчсен бол телберийн акт тогтооно", Монгол Улсын Еренхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага егех, телберийн акт тогтоох" журмын 4.2.3 "бүртгэл, тооцоог зерүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн"-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон байрны зардал 2,085,000.00 /хоёр сая наян таван мянган/ тегрегийг буруутай албан тушаалтнаар нехен телүүлж, Үндэсний аудитын газрын Терийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд тевлерүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний едрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/, нягтлан бодогч /Г.Менхтер/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАДАГДОРЖ
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Зангийн газрын 4 дүгээр байр. Утас 51-264200

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 599/A0150458 Улаанбаатар хот
СЭХ ТГ- 2025/064/НБ-СТА тогтоол

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий компанитай 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр 8,247,000,000.00 /найман тэрбум хоёр зуун дечин долоон сая/ төгрөгөөр "Барилга байгууламж худалдаж авах тухай" гэрээ байгуулсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр дээрх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, үнийн дүнгийн 70 хувь буюу 5,772,900,000.00 /таван тэрбум долоон зуун далан хоёр сая есөн зуун мянган/ төгрөгийн урьдчилгааг гүйцэтгэгч компанийн дансанд шилжүүлсэн боловч одоог хүртэл барилгыг хүлээн аваагүй, гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулаагүйгээс оффисын түрээсийн үргүй зардал гаргаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно", 40.2.1 "энэ хуулийн 40.1-д заасныг бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Үр ашигтай байх", "Барилга байгууламж худалдаж авах тухай" гэрээний тусгай нөхцөлд төлбөр төлөх хугацааг "Нийлүүлэгч барилга байгууламжийг захиалагчид хүлээлгэн өгч, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний өмчлөх эрхийг шилжүүлсний дараа 14 хоногийн дотор төлбөрийг бүрэн шилжүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилга байгууламж худалдаж авах тухай гэрээний дагуу гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулаагүйгээс оффисын түрээсэнд олон сараар үргүй зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/, нягтлан бодогч /Г.Менхтөр / нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ЧАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр.
Утас 51-264230

Z Alban Shaardlaga 2025 0314 SNAG-39 Duut

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 600/D0150458 Улаанбаатар хот
СНМТ- 2025/064/НА- СТА-ТОЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар тогтоосон актын төлбөр 2,140,356.00 /Хоёр сая нэг зуун дөчин мянга гурван зуун тавин зургаан/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон актын төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр авлага үүсгэж, барагдуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/, нягтлан бодогч /Г.Менхтер / нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ЦАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264233

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 601/P0150458
СНБТ-6025/064/НА-СТА-7941Г

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцох тухай

Терийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Терийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32 мөнгөн гүйлгээ байршуулаагүй, емнех аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, Терийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Терийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд терийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд терийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулаагүй,терийн аудитын байгууллагаас хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ганхүү/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.ЦАЦАГДОРЖ
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.НАСАНБУЯН

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс